



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/621

Хэрлэн сум

Нарийн мэргэжлийн эмч нарын
хамтарсан үзлэгт хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдааны “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 6 дугаар тогтоолын хавсралтын 2.1.1, 2023 оны 3-р сарын 09-ний Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай хорьдугаар хуралдааны 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Солонгос Улсын Чусон их сургуулийн эмнэлгийн эмч нартай хамтран нарийн мэргэжлийн үзлэгийг аймгийн хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 9,500,000 (есөн сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 12 дугаар сарын 07-ны
Д/621 дугаар захирамжийн хавсралт

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардалын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Сургалтын байрны түрээс	5 өдөр	150,000	750,000
2	Байрлах байрны төлбөр	10 хүн 5 хоног	160,000	8,000,000
3	Сургалтын хэрэгсэл	30	25,000	750,000
Нийт дүн				9,500,000